

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 22
<i>1. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</i>	7 – 8
<i>2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	8 – 11
<i>3. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	11 – 19
<i>4. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал</i>	19 – 22

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 4 дүгээр сарын 22-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 18 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

*Томилолттой: А.Ариунзаяа, Т.Доржханд, Б.Хэрлэн;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Н.Номтойбаяр, Н.Учрал, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Ундрэм, Б.Чойжилсүрэн;
Тасалсан: Л.Оюун-Эрдэнэ.*

Нэг.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасан “Энэ хуулийн 5.1-д жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүнээс 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т “Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ.” гэж, 39.11-д “Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.” гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

-Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

-Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй тул анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатган явуулах гэсэн горимын саналыг гаргав.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	16
Татгалзсан:	5
Бүгд:	21

76.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, О.Алтангэрэл, Б.Энхбаяр, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар хариулж, тайлбар хийв.

С.Зулпхар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаарх танилцуулгыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

С.Зулпхар: Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 4
Бүгд: 21

81.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 38 минут үргэлжилж, 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 68.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 56 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “ИХ ЗАСАГ” танхим
13 цаг 18 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Зулпхар: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 4 сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Монгол Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Монгол Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Монгол Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Лувсаннъямын Гантөмөр, Монгол Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа, Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Монгол Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа, Монгол Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа, Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн, Монгол Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилэгийн Лодойсамбуу, Монгол Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбилигийн Одбаяр, Монгол Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир нар хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирц 62.5 байна. Хуралдааны ирц бүрэн хангагдсан байна. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төсөл бий. Анхны хэлэлцүүлэг явагдах учиртай.

Гуравдугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Ажлын хэсэг байгуулах тухай.

Дөрөв дэх асуудал. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал байгаа юм.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж Байнгын хорооны гишүүдээс асуулт санал байна уу? Хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуулт санал байхгүй. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан байдаг.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Зарим гишүүд бэлэн байдлаа хангаарай. О.Алтангэрэл гишүүн орж ирлээ. Орсон уу? Орж ирлээ. Болсон байна.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 8 гишүүнээс 2026 оны 4 сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад оролцсон 20 гишүүний 15 нь буюу 75.0 хувь дэмжсэн байна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг
хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан,
анхны хэлэлцүүлэг/**

Хоёр дахь асуудал. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн Б.Баярбаатар уншиж танилцуулна.

Б.Баярбаатар гишүүнийг урьж байна.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэж, 12 дугаар дүгнэлт гарган Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн.

Үндсэн хуулийн цэц уг дүгнэлтдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт уг асуудлыг долоо хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасанд нийцээгүй байна гэж, мөн хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг асуудлыг долоо хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 44 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасанд нийцэхгүй байна гэж дүгнэсэн.

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор тогтоолоор уг дүгнэлтийн ийг хүлээн зөвшөөрсөн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очироор ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Баярбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 2 удаа хуралдаж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Та бүхэнд тараасан болно.

Хуулийн төсөлд гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэх, мөн Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал асуудлыг 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэхээр тусгасан болно.

Ажлын хэсгийн боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж өгөхийг Байнгын хорооны гишүүдээс хүсье. Баярлалаа.

С.Зулпхар: Б.Баярбаатар гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ гэж, 39.11-д гишүүн хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэж заасан.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Асуулт, санал. Алга байна. Ц.Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Ажлын хэсгээс нэгхэн зүйл тодруулъя.

Энэ ийм чухал Үндсэн хуультай холбоотой асуудлаа бас ингээд хэдүүлээ үзээгүй ч юм уу. Энэ чинь одоо ингээд хоногийг нь зөрүүлсэн явж байсан гэж ойлгож болох уу? Тийм л юм уншигдаж байна.

Тэгээд энэ нь нөгөө бид чинь нэг асуудал яригдаад Ерөнхий сайдыг дэмжээгүйг дэмжинэ ч билүү ингээд бөөн хэрүүл маргаантай хэлэлцэгдсэн шүү дээ. Тийм ээ. Хэлэлцэгдээд өнгөрсөн.

Тэгээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр энэ асуудал нь маргаантай байна гээд явсан шүү дээ. Тийм ээ. Үүнтэй ямар нэгэн байдлаар уялдах юм байгаа юу? Ямар нэгэн холбоос. Ингээд хэлэлцсэн нь. Урьд нь энэ чинь ингээд хуулийг нь засалгүйгээр явж байсан байна шүү дээ. Нийцүүлэлгүйгээр. Үндсэн хуультай.

Тэгэхээр энэ хоёрын хооронд уялдаа холбоо ямар нэгэн тийм засаж зохируулах. Үлнээс хамаарах юм байгаа юу гэдэг асуулт асууя.

С.Зулпхар: Ажлын хэсгийн гишүүн Б.Баярбаатар асуултад хариулъя.

Б.Баярбаатар: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа зөв өө. Яг л энэ нэг хоногийн наана цаана л асуудал. Дэгийн тухай хуульд 3 гэж тавих ёстойг 7 гээд тавьсан л өөрөө Үндсэн хуулийн зөрчил гэж үзээд цэцийн дүгнэлт гарсан.

Энэ дүгнэлтийн дагуу өнөөдөр энэ 7 гэсэн хоногийг 3 хоног гэж өөрчилж хуулийн төсөлд оруулахаар орсон.

Хоёр дахь асуудлын хувьд өнөөдрийн бидний хэлэлцэж байгаа асуудалтай цэцийн дүгнэлт холбоогүй. Өмнө нь Байнгын хорооны дарга ахалж байсан. Их Хурлын тухай хууль болон дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой ажлын хэсэг байгуулагдаад энэ төсөл дотор харин таны асуудлууд тэр хэлэлцэх асуудал дотор бол яваа юм билээ.

Дараа нь Байнгын хороонд орж ирэх байх. Өнөөдрийн энэ цэцтэй холбоотой шийдвэрт таны асуудал байхгүй гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Зулпхар: Ажлын хэсгийн гишүүн Б.Баярбаатарт баярлалаа. Ц.Туваан гишүүн дэмжиж тодруулах зүйл байна уу? Баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Б.Баярбаатар гишүүнээс горимын санал гарч байна.

Б.Баярбаатар: Анхны хэлэлцүүлгийн үед зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтад нь явуулах горимын саналыг гаргаж байна.

С.Зулпхар: Б.Баярбаатар гишүүн горимын санал гаргасан.

Горимын саналтай холбогдуулаад би санал хураах учиртай.

Анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтарсан байдлаар явуулъя гэсэн ийм горимын санал гаргаж байна. Санал хураалтад бэлтгэе.

Горимын саналаар санал хураая. /алх цохив/

Санал хураалтад оролцсон 21 гишүүнээс 16 гишүүн буюу 76.2 хувь нь дэмжлээ. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Ажлын хэсэг байгуулах тухай/

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсэг байгуулах тухай”. Хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын хууль Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын 2025 оны жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг Төрийн байгуулалтын байнгын хороогоор 2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр хэлэлцсэн бөгөөд хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, цаашид биелэлтийг сайжруулах чиглэлээр санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулах тогтоолын төслийг боловсруулсан байгаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.7 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлттэй танилцах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн
С.Зулпхар Улсын Их Хурлын гишүүн
Ч.Ундрам Улсын Их Хурлын гишүүн
О.Алтангэрэл Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг /А.Ариунзаяа/-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /А.Ариунзаяа/-д даалгасугай.

Хуралдаан даргалагч гэсэн ийм тогтоолын төсөл байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан асуулт асууна.

Ц.Туваан: Энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгээд цагаа олсон асуудал гэж бодож байна.

Улсын Их Хурал дээр батлагдсан хууль, Их Хурлын тогтоолууд яг амьдрал дээр хэрэгжих дээрээ бас хэрэгжиж өгөхгүй. Ингээд нэг сайхан хууль батлагдаад л тэгээд л мартагддаг.

Тэгээд тэр нь чухам араас нь гүйцэтгэл нь ямар байна, Засгийн газар дээр энэ нь яаж хэрэгжиж байна, түүнийг дагасан. Бид хэд хуулиа дагасан баахан журам ярьдаг. Тэрийгээ хүлээдэг. Ингээд энэ асуудлууд нь хоцрогсон юм зөндөө байна.

Тэгэхээр энэ асуудлыг яг энэ Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гэж хязгаарламааргүй байна. Бид чинь Төрийн байгуулалтын байнгын хороо учраас бүх л хууль, ялангуяа амьдралд нэлээн шаардлагатай, хэрэгжилтээ хүлээж байгаа ийм хууль Улсын Их Хурлын тогтоолуудыг хамруулж авч үзэж болох уу гэдэг асуулт байна.

Тэгээд энэ дотроос одоо тэр Малчны хуулиас өгсүүлээд, төрөөс олгох урамшууллаас эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцох гээд хууль байна. Дээрээс нь Их Хурлын тодорхой Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн маш олон тогтоолууд байна.

Тэгэхээр үүнийг хамрах хүрээг нь тийм. Мэдээж бүгдийг нь гэвэл амжихгүй байх.

Тэгэхдээ энэ дотор яг хүлээлт үүсгэсэн байгаа хууль, Их Хурлын тогтоолуудын хамрах хүрээг оруулж болох уу гэдэг асуулт байна.

С.Зулпхар: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Яг одоо үүнтэй төсөөтэй ижил үйл ажиллагаа Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр хийгдсэн. Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны өөрийнх нь эрхлэх чиглэлийн хүрээн дэх тодорхой асуудлуудаар гарсан хууль тогтоомжуудын хэрэгжилтээр үнэлгээ хийгдсэн байсан.

Энэ үнэлгээ зарим талаар тодорхой салбарууд дээр зохих түвшинд шаардлага хангаж байхад зарим салбарууд дээр огт шаардлага хангахгүй ийм байдал үүссэн. Тэр битгий хэл зарим хууль тогтоомж өөрөө хэрэгжих хүрээ болон хэрэгжих цаг хугацааны хувьд нэлээн хоцорсон, эсвэл ач холбогдол нь алдагдсан ийм нөхцөл байдлууд тогтоогдсон.

Тэгээд энэ дээр ажлын хэсэг дүгнэлт хийгээд, үүний дагуу тодорхой шийдвэрүүд гаргасан. Зарим хууль тогтоомжийн төслүүдийг хүчингүй болгох чиглэлээр саналууд гарсан. Зарим хууль тогтоомжийн төслүүдийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр чиглэлүүд гарсан байгаа.

Тэгэхээр манай Байнгын хорооны харьяалах тодорхой чиглэлүүдтэй холбоотой ямар ч хууль тогтоомжийн төслийг бид Байнгын хорооны хүрээнд энэ ажлын хүр хэсэгт чиглэл болгож үүнийг үнэлүүлэх, үүнтэй холбоотой санал зөвлөмж гаргуулах, тодорхой чиглэл гаргуулах бүрэн боломжтой гэсэн ийм дүгнэлтийг би урьдчилсан байдлаар Та бүхэнд танилцуулж байгаа юм.

Тийм учраас таны хэлсэн санал энэ хүрээнд хэрэгжээд явах бүрэн боломжтой.

Ц.Туваан гишүүн тодруулна.

Ц.Туваан: Сая таны үгээр чинь нэг бол боломжтой ч юм шиг, нэг бол боломжгүй ч юм шиг ийм хариулт байна л даа.

Тэгэхээр миний асуулт бол бид Төрийн байгуулалтын байнгын хороо юм чинь түрүүний хэлсэн Нийгмийн бодлогын байнгын хороо ч юм уу, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо ч юм уу тэд нараасаа асуугаад тодорхой шийдлээ хүлээгээд байгаа хууль тогтоол нь гарсан журам нь Засгийн газар дээр гарахгүй хүлээгдээд байгаа энэ асуудлуудыг нь асууж аваад нэг, хоёр хууль ч юм уу аваад нэгтгээд хэлэлцвэл яасан юм бэ. Ийм боломж байгаа юу гэж асууя.

С.Зулпхар: Ц.Туваан гишүүний саналыг тэмдэглэлд оруулъя.

Ажил хэргийн шугамаар болон гарсан саналын хүрээнд удирдамжид тусгаж бид хийж болох зүйл.

Та бүхэн мэдэж байгаа. Улсын Их Хурлын хаврын чуулганыг би “ЧӨЛӨӨЛБЕ” гэдэг том зорилт тавьсан.

“ЧӨЛӨӨЛБЕ” зорилтын хүрээнд Улсын Их Хурлаас гарсан бүх хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр бүхий л салбарт анхаарал хандуулах чиглэл байгаа.

Тэгэхээр үүнтэй уялдсан байдлаар ажлын хэсгийн удирдамж дээр бид үүнийг анхааруулж энэ ажлыг чиглэл болгоё.

О.Алтангэрэл гишүүн асуулт асууя.

О.Алтангэрэл: Тогтоолыг дэмжиж байна.

Тэгээд сая Ц.Туваан гишүүний ярианд гарч байна. Энэ хэрэгжихгүй байгаа хууль тогтоомжуудыг одоо ер нь яах юм бэ гэж. Сүүлдээ Засгийн газар өөрсдийнхөө хэрэгжүүлэх ёстой хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байж байгаад нэг жил, хоёр жил өнгөрөөж байгаад энэ чинь хэрэгжихгүй байна, үүнийгээ хүчингүй болгооч гээд Улсын Их Хурал руу оруулж байна шүү дээ.

Ингэж үзэмжээрээ өөрсдийгөө хэрэгжүүлэх дуртайгаа хэрэгжүүлчхээд, тэгээд шийдвэр болгон хэрэгжүүлэхэд амар хялбар байхгүй шүү дээ. Зохих нөөц шаардана, зохих зориг шаардана.

Тэгээд Засгийн газар нь хэрэгжүүлэхгүй байж байгаад эргээд энэ шийдвэр чинь хэрэгжихгүй байна, үүнийгээ хүчингүй болгооч гэдэг ийм байдал ер нь даамжирлаа.

Одоо хамгийн том жишээ энэ Малчны хууль шүү дээ. Баахан малчны хүлээлттэй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нь журам гаргана гэсэн. Тэгэнгүүтээ оны эхэнд болохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нь журмаа гаргана. Нийгмийн даатгалын асуудал шийдвэрлэнэ гээд ярилцлага өгөөд байж байсан. Ерөнхий сайд асуулга тавиад би саяхан бичиг авахад боломжгүй гэсэн гэсэн хариу өгч байгаа байхгүй юу.

Төрийн хууль тогтоомжийг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боломжгүй гэдэг хариу өгдөг гүйцэтгэх засаглалтай байж бид энд асуудал шийдэж байна, ард түмний төлөө юм хийж байна гэж худлаа ярьж суугаад яах юм бэ.

Ийм учраас энэ ажлын хэсэг нэлээн сайн ажиллах шаардлагатай байх.

Тийм учраас ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллахдаа идэвх зүтгэлтэй нэлээн сайн ажиллана гэж бодож байгаа.

Тэгээд надад нэг санал байгаа юм. Удирдамжийн 1.2.7 дээр “Зорилт хэрэгжүүлэх үйл ажиллагаа” гэсэн хэсэг дээр 7 дээр нь “хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэр хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, санал, дүгнэлт, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөмж гаргах” гэж байгаа юм.

Энэ “хариуцлагыг нэмэгдүүлэх” гэсэн хоосон үг хэрэггүй. Угаасаа хэрэгжихгүй байгаа юманд.

“Хариуцлага тооцуулах” гэж байна. “Нэмэгдүүлэх” гэдэг үгийг өөрчлөөд “хариуцлага тооцуулах чиглэлээр зөвлөмж гаргах” гэж удирдамжийг өөрчилж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа. Нэг л үг сольж байна гэсэн үг.

Р.Сэддорж: О.Алтангэрэл гишүүний гаргасан саналыг ажлын хэсгийн удирдамжид 1.7-д тусгая.

Сая яригдсан зүйлтэй шууд холбоотой. Ц.Туваан гишүүн ч гэсэн яг энэ асуудлыг л хэлж байна л даа. Хууль батлагддаг. Хуулийг хэрэгжүүлээгүй байдаг.

Тэгээд тодорхой хугацааны дараа хууль хэрэгжиж болсонгүй гэдэг хариулт өгөөд сууж байгаа нь өөрөө хангалттай биш. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, парламентын засаглалтай улсад хууль тогтоох байгууллага нь хуулиа тогтоодог, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Засгийн газар нь үүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар төрийн байгуулалтын хувьд хариуцлага байх ёстой.

Тэгэхээр үүнтэй холбоотой зүйлийг бид парламент өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд чиглэл болгодог. Шаардлагатай үед хариуцлага тооцдог байх ёстой гэсэн энэ зүйлийг Та бүхэн бүгд ярьж байгаа учраас энэ асуудлыг энд тухайлан тусгах нь зүйтэй гэж бодож байна.

О.Алтангэрэл гишүүний гаргасан саналтай холбогдуулаад саналтай асуулттай гишүүн байна уу? Байхгүй. /алх цохив/

О.Алтангэрэл гишүүний саналыг Ажлын хэсгийн удирдамжийн 1.7-д нэмэлтээр засаж тусгалаа.

Б.Энхбаяр гишүүн асуулт асууна.

Б.Энхбаяр: Тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

Ер нь парламент хууль тогтоохоос гадна хуулийнхаа хэрэгжилт, гүйцэтгэлийг араас нь нэхэж шаардаж явах ёстой.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын түр хороо–

- “сонсгол”,
- “асуулга”,
- “асуулт”–

-гээд их олон янзын хяналтын хэлбэрүүд байдаг. Мөн нэг нь “ажлын хэсэг”.

Тэгэхээр ажлын хэсгийн тухайтад би нэгдүгээрт хууль тогтоомжийн хэрэгжилтийн гүйцэтгэлээ хэдэн оноос хэдэн оны хооронд гэдэг тийм цаг хугацааны хүрээ хязгаар тавивал илүү их зүгээр байх гэж бодож байна.

1992 оноос хойших сүүлийн 35 жилийн Их Хурлын шийдвэрийн хэрэгжилт гэвэл энэ чинь бүр хэдэн жилээр хийгээд дуусахгүй ажил руу давхиад орно.

Хоёрдугаарт, сая гишүүд гаргаад байна. Энэ салбар дундын, салбар хоорондын хүрээ хязгаар дээр тийм хашилт хана хэрэм байна уу, байхгүй юу. Тэгвэл их зүгээр болно.

Нөгөө талаасаа парламент ба гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл солилцоог нягтруулах чиглэл дээр ажлын хэсэг удирдамж юмандаа оруулж өгвөл.

Засгийн газар юу хийгээд байна вэ гэхээр. Би чинь ажлаа аваад 3 дахь долоо хоногтоо, 8 дахь Байнгын хороондоо Их Хурлын хууль тогтоомжийн шийдвэрийн хэрэгжилт танилцуулаад яваад байгаа байхгүй юу. Одоо ингээд бүх Байнгын хороонд.

Тэгээд эндээс харагдаж байгаа юм юу байна вэ гэхээр энэ нэг тийм хэлбэр төдий. Тэгээд нэг нь танилцсан, нэг нь танилцуулсан болоод. Нөгөө талдаа энэ 3 долоо хоног бүх яам, агентлагийн дарга, удирдлагууд нь энд.

Хойд талын арын ажил байхгүй энд өнжөөд байдаг нэг тийм юу байдаг юм билээ.

Тийм учраас Ерөнхий сайдын ч бодлого байгаа. Засгийн газар ер нь танхимдаа тайлан мэдээ авдаг, ялангуяа бичгээр. Цаасан юмыг ер нь халж байгаа юм.

Тэгээд үүнийгээ ер нь Их Хурлын гишүүдтэй **real-time** холбоод Их Хурлын гишүүд байнга хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг гар утас, планшетаасаа үзээд явдаг, шаардлагатай юмнуудаа нэхээд шууд авдаг явбал нэг тийм байнгын, тасралтгүй, амьд болох юм болов уу гэсэн ийм санал байгаа юм.

Ажлын хэсгийн түвшинд ажил хэрэгчээр хамтарч ажиллая гэж бодож байна.

С.Зулпхар: Б.Энхбаяр гишүүн санал байна.

Яах вэ, саналтай холбогдуулаад цаг хугацааны хувьд тодорхой зааж өгсөн. Сүүлийн 10 жилд гарсан шийдвэрүүдийг ажлын хэсгийн хүрээнд авч үзэх юм гэж.

Өнгөрсөн хугацаанд ажлын хэсгийн ажиллах практик байсан. Үүн дээр цаг хугацааг нь тодорхой зааж өгөхгүй бол болохгүй байна гэсэн ийм зүйл яригдаж байсан. Би ажлын хэсэгт байсан учраас Та бүхэндээ энэ асуудлыг хуваалцаж байгаа юм.

Тэгэхээр энэ их тодорхой зааж өгсөн гэдгийг энд танд тайлбарлаж хэлье.

Салбар дундын шинжтэй асуудлууд, саяны малчны тухай хууль чинь нэг талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны асуудал юм шиг мөртлөө нөгөө талдаа салбар дундын шинжтэй ийм нөхцөлүүдийг гаргаж ирж байгаа юм.

Тэгэхээр үүнийг шаардлагатай бол ажлын хэсэг өөрөө татаж аваад үзэх бүрэн боломжтой гэсэн ийм чиглэлтэй байна.

Ер нь Улсын Их Хурлын гишүүн шаардлагатай бол ямар ч хууль тогтоомжийн төсөл, бусад түүний хэрэгжилттэй холбоотой асуудлаар өөрөө асуулт асуух, асуудал хөндөх бүрэн эрхтэй учраас үүнийг тухайн үед нь ажлын хэсэгт өөрт нь чиглэл болгоё.

Таны саналуудыг хуралдааны тэмдэглэлд авлаа.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлаас гарч байгаа тогтоол шийдвэрүүдийн биелэлтээр бид зайлшгүй хяналт тавьж байхгүй бол болохгүй.

Хамгийн гол хаяад байгаа зүйл маань энэ шүү дээ.

Тийм болохоор Байнгын хорооноос гарч байгаа тогтоолыг дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл хууль тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрүүд дээр биелэлттэй нь танилцах гээд байна шүү дээ. Тийм.

Нэгдүгээрт, сая би тодорхой хариулт бусад гишүүдийн асууснаас авсангүй юу гэж ойлгоод байна. Зөвхөн Төрийн байгуулалтын байнгын хорооноос гарч байгаа тогтоол шийдвэрүүд үү, эсвэл энэ тогтоол дээр зааснаар Улсын Их Хурлын шийдвэрүүд гэж байгаа шүү дээ. Бүх салбарууд.

Одоо жишээ нь Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр миний мэдэх ажлын хэсгийг нь ахалж байгаад гаргасан 2, 3 шийдвэр Засгийн газар дээр очоод усанд хаясан чулуу мэт алга болсон.

Үүнийг тэр хяналт шалгалтынх нь асуудал эрхэлсэн тухайн үеийн сайдаас нь асуугаад мэдэхгүй. Ийм байдалтай байгаа байхгүй юу.

Тийм болохоор энэ дээр нэгдүгээр асуулт бол нийт Байнгын хороодын, ер нь салбар дундын том хэмжээнд ажиллах боломж бололцоо байна уу? Үүгээр ингэж ажиллах юм байгаа биз дээ гэдгийг бол асуух гээд байна. Ингэж ажиллах шаардлага байгаад байна.

Хоёрдугаарт, Байнгын хороон дээрээ Их Хурлын шийдвэрийн биелэлт гэдэг дотор чинь Байнгын хорооны тогтоол, шийдвэрүүд орж байгаа юу?

Үүнийгээ жоохон тодруулах хэрэгтэй байх. Тийм. Удирдамждаа эсвэл оруулдаг юм уу? Үүнийг жоохон тодруулах хэрэгтэй байх.

Гуравдугаарт, энд хуульчид ерөөсөө харагдахгүй байгаад байна. Б.Баярбаатар, С.Зулпхар, Ч.Ундрам, Ө.Шижир гишүүн байна, А.Ариунзаяа гишүүд байна. Эндээс хуульчид. О.Алтангэрэл орсон уу? Ганц нэг хуульчдаа оруулсан нь зүйтэй байх гэсэн ийм л гурван санал байна. Окэй.

С.Зулпхар: Ж.Бат-Эрдэнэ гишүүн санал байна.

Ямартаа ч Улсын Их Хурлын Байнгын хорооноос ажлын хэсэг гараад бид удирдамжаар ихэнх тохиолдолд өөрийнх нь харьяалах чиг үүргийн хүрээний хууль тогтоомжийн төсөл дээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байдал дээр ажиллаж байгаа.

Гэхдээ энэ дээр нэгэнтээ Улсын Их Хурлын гэж заадаг нь саяын салбар дундын шинжтэй тодорхой асуудлууд байх юм бол үүнийг татаж авч энэ асуудал дээр санал, дүгнэлт гарах нь ажлын хэсгийн эрх нь болж байгаа юм.

Тэгэхээр үүнийг саяын тэмдэглэлээр бид үндсэндээ хэллээ шүү дээ. Бид үүнийг шаардлагатай түвшинд нь татаж аваад Та бүхэн ажиллаарай гэдэг ийм чиглэлийг Байнгын хорооны гишүүд өгч байна.

Улсын Их Хурлын тогтоол шийдвэрээс гадна Байнгын хорооны тогтоол шийдвэр байх уу. Байнгын хорооны тогтоол шийдвэр байна. Угаасаа үүнтэй холбоотой бүхэлд нь Улсын Их Хурлын тогтоол шийдвэр гэдэг бол энэ Байнгын хороо, дэд хорооноос гарсан шийдвэрүүдийг давхар авч үзэж байгаа гэдгийг хэлье.

Хуульч гишүүн О.Алтангэрэл гишүүнийг сая Ө.Шижир гишүүний оронд санал болгосон. Энэ дагуу бид нэмж оруулсан. Та бүхэн үүнийг дэмжиж өгөх байх гэж бодож байна.

Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

“Ажлын хэсэг байгуулах тухай”. Санал хураалт.

Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтдаа бэлдье гишүүд. Санал хураалт.

Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад оролцсон 21 гишүүнээс 16 гишүүн буюу 76.2 нь дэмжиж, санал дэмжигдлээ.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Одоо дөрөв дэх асуудал руугаа оръё.

Дөрөв.Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал

Дөрөв дэх асуудал. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулна. /алх цохив/

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулгыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал танилцуулна. /алх цохив/

Ж.Батжаргал: Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Болдын Жавхлангийн нэрийг дэвшүүлж байна.

Болдын Жавхлан 1975 онд Дархан хотод төрсөн. Ам бүл 3.

1990 онд Дархан хотын 17 дугаар дунд сургууль,
1992 онд Сүхбаатар аймгийн 1 дүгээр дунд сургууль,
1997 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийг Банкны эдийн засагч мэргэжлээр,

2008 онд Америкийн Нэгдсэн Улсын Калифорнийн их сургууль,
2009 онд Америкийн Нэгдсэн Улсын Индианагийн их сургуулийг тус тус төгссөн.

1997-1999 онд Монголбанкны хяналт шалгалтын газрын хянан шалгагч,
1999-2000 онд Монголбанкнаас Хөдөө аж ахуйн банканд бүрэн эрхт төлөөлөгч, эрх хүлээн авагч,

2000-2004 онд Монголбанкны Хяналт, шалгалтын газрын ахлах хянан шалгагч,

2004-2006 онд Худалдаа, хөгжлийн банкны Үйл ажиллагаа эрхэлсэн захирал,

2006-2007 онд Худалдаа, хөгжлийн банкны Дэд ерөнхийлөгч,
2010-2016 онд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч,
2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 3 удаа сонгогдон ажиллаж байна.

2016-2020 онд Улсын Их Хурлын Нутгийн удирдлагын дэд хорооны дарга,
2020-2021 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга,
2021-2026 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар ажилласан.

Улсын Их Хуралд ажилласан байдал, мэдлэг, чадвар, туршлагыг нь харгалзан Болдын Жавхланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Хэлэлцэн дэмжиж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Зулпхар: Байнгын хорооны гишүүдээс Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар өөр саналтай гишүүд байна уу? Өөр саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 23.4-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно гэж заасан байгаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй.

Үг хэлэх тусдаа байгаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуулттай гишүүн байхгүй. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 23.4-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно гэж заасан байгаа.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуулт асуугдсан. Одоо үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Үг хэлэх гишүүн байхгүй. Үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Болд овогтой Жавхланг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтын дүнг танилцуулъя.

Санал хураалтад оролцсон 21 гишүүнээс 17 гишүүн буюу 81.0 хувь нь дэмжлээ.

Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулна. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 38 минут үргэлжилж, 13 цаг 56 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД